

СУВИЛАХУЙН СУРГУУЛИУДЫН АНАГААХЫН ХИМИЙН СУРГАЛТЫН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

П.Орхонтуяа, Д.Энхмаа, Ц.Сумьяа

Түлхүүр үг: Анагаахын химийн агуулга, сургалтын арга, үнэлгээ

Үндэслэл: Сувилахуй гэдэг нь үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд чиглэсэн цогц тусламж үйлчилгээг үзүүлдгээрээ онцлог мэргэшил юм. Энэхүү өгүүлэлд Монголын сувилахуйн мэргэжлийн сургуулиудад анагаахын химийн сургалтыг зохион байгуулж буй байдал, Тухайлбал, агуулга, арга хэлбэр, үнэлгээнд хийсэн судалгааны дүн, цаашид боловсронгуй болгох асуудлыг тусгасан болно.

Зорилго: Бидний судалгаа нь Монголын сувилахуйн мэргэжлийн сургуулиудад анагаахын химийн сургалтыг зохион байгуулж буй байдал, Тухайлбал, агуулга, арга хэлбэр, үнэлгээнд хийсэн судалгааны дүн, цаашид боловсронгуй болгох асуудлууд болно.

Судалгааны арга

Баримт бичигт судалгаа хийх арга

Асуулт, ярилцлагын арга

Анализ, синтезын арга

MSExcel, XPSS 11 программ

Үр дүн

Судалгаанд Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй УБ ЭМШУИС - ийн Сувилахуйн сургууль, Дархан хот Говь - Алтай аймаг, Дорноговь аймаг дахь Анагаах ухааны коллеж зэрэг улсын тав, хувийн зургаан сургуулийн 274 суралцагчид, 251 төгсөгчид тус тус хамрагдсан. Үүнээс үзэхэд, судалгаанд хот, хөдөө төвийн болон бүс нутгийн суралцагчид төгсөгчид хамрагдсан.

Судалгааг химийн хичээлийн агуулга арга хэлбэр, үнэлгээ гэсэн дараах чиглэлээр явууллаа. Химийн хичээлийн агуулга нь сувилагч мэргэжилтний мэргэжлийн онцлог, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл хоорондын интеграцлал нийгмийн эрэлт хэрэгцээнд үндэслэн өөрчлөгдөх шаардлагатай байгаа бөгөөд судалгаа хийж үзэхэд ихэнх сургуулиуд

анагаахын боловсролтой төдийлөн холбохгүй, хичээл хоорондын интеграцчилал багатай агуулгыг судалж байна.

Химийн хичээлийн агуулга нь мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийн агуулгатай уялддаг эсэх гэсэн асуултад тийм гэсэн хариултыг 65 буюу 23.7 %, үгүй гэсэн хариултыг 209 буюу 76.3 % нь өгсөн байна. Төгсөгчдөөс мэргэжлийн ажлаа хийхэд химийн хичээлийн холбогдол ямар болохыг судлахад сайн, 55.8% нь дунд, 7.6% нь муу, 9.1% нь огт үгүй гэж үнэлжээ. Энэ нь химийн хичээл нь мэргэжлийн хичээлүүдийн агуулгатай холбоо багатай байгааг харуулж байна.

Таны суралцах хугацаанд сургалтын ямар хэлбэрийг хамгийн өргөн ашиглаж байна вэ? гэсэн асуултад суралцагчид лекцийн хичээлийг 48.5%, туршилтын ажлыг 27.4 %, семинарыг 21.5%, бие даалтыг 2.6% гэж тус тус сонгожээ. Харин төгсөгчид лекцийн хичээлийг 48.8% туршилтын ажлыг 18.1%, семинарыг 29.9% бие даалтыг 3.2% гэж тус тус сонгожээ. Үүнээс үзэхэд, лекцийн хичээл дийлэнх хувийг эзэлж харин лаборатори, дадлагын ажил бага орж байна.

Хими сургалтад дараах зүйлүүдийн алийг нь түлхүү анхаарах нь илүү ач холбогдолтой гэж үзэж байна вэ? гэсэн асуултад суралцагчид мэдлэг 47.4%, чадвар 35.4% хандлага 17.2% эсэн хариултыг сонгожээ. Харин төгсөгчид мэдлэг 51%, чадвар 37%, хандлага 12% гэсэн байна. Энэ нь суралцагчдад чадвар, хандлагыг суралцах хугацаанд нь төлөвшүүлэхийн чухал болохыг харуулж байна.

Химийн хичээлээр эзэмшсэн мэдлэгийг ямар аргаар үнэлдэг вэ? гэсэн асуултад тестийн хэлбэрийг 47.9 %, бичгийн ажлыг 25.3 %, аман шалгалт 20.9 % бусад 5.9 % тус тус сонгожээ. Төгсөгчид тестийн хэлбэрийг 21.6 % бичгийн

ажлыг 45.7%, аман шалгалт 21.1%, бусад 11.6% гэсэн хариултыг сонгожээ. Судалгааны үр дүнгээс харахад мэдлэгийг түлхүү үнэлж байгаа нь харагдаж байна. Чадварыг түлхүү үнэлэх нь оюутнуудыг чадваржуулах, түүнийг бодтой үнэлэх алхам болно.

ДҮГНЭЛТ

Сувилахуйн мэргэжилтний хэрэгцээнд суурилсан химийн хичээлийн агуулга нь боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахуйц, мэргэжилтэнд мэдэх, бүтээх, амьдрах, нийгэмших арга ухааныг төлөвшүүлэх, анагаахын боловсролын эрэлт хэрэгцээг хангахуйц цогц бүтэцтэй байх нь чухал юм. Химийн хичээлийн арга хэлбэрийг сургалтын хэрэгцээг таниулах, суралцагчийн сурах үйл ажиллагаанд тулгуурлан сургалтыг байгуулах, сурах-сургах холбоог чанарыг сайжруулах зөв сонгох нь чухал бөгөөд лекцийн хичээлээс лаборатори дадлага бие даалтыг түлхүү оруулахаар төлөвлөн хэрэгжүүлэх. Химийн хичээлээр суралцагчдад чадварыг үнэлэх төвшнийг тодорхойлох, эргэх мэдээллээр хангах, оюутнуудын сурах үйл ажиллагаанд туслах, дэмжлэг үзүүлэх бодтой үнэлэх нь нэн тэргүүнд хэрэгжүүлэх зүйл болж байна.